



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/217

Хэрлэн сум

Урьдчилан сэргийлэх ажилд
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1. Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, 32.1.10 дахь заалт, Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Объектын болон ой, хээрийн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулахад 2,000,000 (хоёр сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай


3. Ард иргэдэд объектын болон ой, хээрийн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг сурталчлан таниулах, санамж, тараах материалыг бэлтгэн зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Онцгой байдлын газрын дарга (хурандаа Ж.Эрдэнэбат)-д үүрэг болгосугай.

4. Дээрх ажилд шаардагдах хөрөнгийг аймгийн гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны
дугаар сарын...-ны өдрийн
дугаар захирамжийн хавсралт

Зардлын тооцоо

№	Нэр төрөл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Дүн
1	Объектын болон ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ард иргэдэд тараах материал бэлтгэх	2670	750	2,000,000
	Нийт			2,000,000